



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ
“ГАН ХИЙЦ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04- сарын 24-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Шийдвэрийн тухай

Тус компанийн 2022 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн болон компанийн Санхүү, үйл ажиллагааны 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлыг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй
2. 2022 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг 95,176720 төгрөгөөр, компанийн үйл ажиллагааны төсвийг 945,302,720 төгрөгөөр баталсугай.
3. 2021 оны үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн тайлангийн үр дүнгээр ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр тооцон ҮЦГХТ-өөр дамжуулан олгохыг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэнд даалгасугай.
4. 2022 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэр, холбогдох материалыг Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нина-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

ГИШҮҮД

М.ДАВААСҮРЭН

Д.ЭНХЧИМЭГ

Б.НИНА

“ГАН ХИЙЦ” ХК-ИЙН БҮХ ГИШҮҮДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦСОН ГИШҮҮД,
ТАРААГДСАН САНАЛЫН ХУУДАСНЫ БҮРТГЭЛ

Ган Хийц ХК

2022.04.24

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Үнэт цаасны компани	Хувьцааны тоо	Саналын хуудасны №
1	М.Даваасүрэн	Би Ди Сек	172580	
2	М.Даваасүрэн	Би Ди Сек	1000	
3	А.Эрдэнэ	Өндөрхан Инвест	280	
4	Чинбат	Өндөрхан Инвест	1482	
5	Д.Ганболд	Өндөрхан Инвест	686	
6	Аргайбэст ҮЦК-ХХК		3398	
7				
8				
9				
10				
11	НИЙТ		179426	


Хурлын ирц:.....

Нийт 242464 ширхэг хувьцаа

$/179426/242464 * 100 = 74\%$

Ирцийг бүртгэсэн :

Тооллогын комиссын дарга  Д.Энхчимэг



**“ГАН ХИЙЦ”ХК-ИЙН 2022 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ХУРЛЫН
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

2022.04.20


Хурал зохион байгуулах газар: “Ган Хийц”ХК-ийн ТУЗ-ийн даргын өрөөнд

Хурал болох цаг: 11:40 цагаас

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-Н, АУДИТЫН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭХ
- ТУЗ-ИЙН 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ, КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ
- НОГДОЛ АШГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ТАНИЛЦУУЛАХ

“ГАН ХИЙЦ”ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ



Хурал зохион байгуулах комисс

Даргаар ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн

Нарийн бичгийн дарга Б.Нина

Хурлын тооллогын комисс

“Ган Хийц”ХК-ийн Хүний нөөцийн менежер Д.Энхчимэг

Борлуулалтын менежер Б.Мөнхголомт

“Эко цаг” ХХК-ийн Нягтлан бодогч Т.Мөнгөнчимэг

Хуралд оролцож байгаа Хувьцаа эзэмшигчдэд бүртгэлийн хуудас тараан ирцийг бүртгэж танилцуулна.

Тооллогын комиссын дарга Д.Энхчимэг

Хурлын дарга хурлыг нээж, дэгийг танилцуулах

Хурлын дарга М.Даваасүрэн

Хэлэлцэх асуудлуудын дарааллын дагуу дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

а/ Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хэлэлцэх

б/ ТУЗ-ийн 2022 оны төсөв, компанийн үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө зардлын төсөв батлах

в/ Ноогдол ашгийн талаар мэдээлэл танилцуулах

Хурлын дарга М.Даваасүрэн

Санал хураалтын үйл ажиллагааг эхлүүлж, саналын хуудасыг хуралд оролцогчдод тараах

Тооллогын комисс Б.Мөнхголомт

Завсарлага: Саналын хуудас бөглөх

10 минут

Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт, хариулт / Санал авч байх хооронд зохион байгуулна/

Тооллогын комиссын саналыг нэгтгэсэн тогтоол, протоколыг танилцуулах

Тооллогын комисс Д.Энхчимэг

Хурлаас гарах шийдвэрийг танилцуулах

Хурлын дарга М.Даваасүрэн

Хурлыг хаах

Хурлын дарга м.Даваасүрэн

“ГАН ХИЙЦ”ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2022.04.24

Ган Хийц ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 24-ны өдрийн 14:40 минутад компанийн ТУЗ-ийн даргын өрөөнд хийв.

Хуралд хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, “Аргай Бест ҮЦК” ХХК-ийг төлөөлж Л.Гантуяа, А.Эрдэнэ, Д.Ганболд, Л.Чинбат, Даваасүрэн нар оролцлоо.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 74% буюу 179426 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц 100% бүрдсэн гэж үзээд хурлыг эхлэв.

Хурлын даргаар Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Нарийн бичгийн даргаар Б.Нина хөндлөнгийн гишүүнээр Эко цаг ХХК-ийн нягтлан бодогч Т.Мөнгөнчимэг нарыг сонгож батлав.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дотоод журмыг тус тус танилцуулж, батлуулав. Хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 11:40 минутад эхлэн 12:40 минутад дуусгахыг санал оруулж батлууллаа.

Бүх хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх, санал оруулж байна. /Хуралд оролцож байгаа гишүүд 100%-ийн саналаар зөвшөөрөв/

Хэлэлцэх асуудал:

- КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-Н, АУДИТЫН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭХ
- ТУЗ-ИЙН 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ, КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ
- НОГДОЛ АШГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ТАНИЛЦУУЛАХ

Хэлэлцсэн нь:

М.Даваасүрэн: Хэлэлцэх асуудлыг бүгдийг танилцуулсны дараа санал асуулгадаа орох уу?

Гишүүд: Дэмжиж байна. /100%/

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу компанийн 2021 оны Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн аудитын дүгнэлийн талаархи мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулав.

Ган Хийц ХК-нь 1985 онд "Барилгын металл хийцийн үйлдвэр" нэртэйгээр байгуулагдаж, жилд 6000 тонн төрөл бүрийн металл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус компани нь 1992 онд Ноён Даваасүрэн Манидарын эзэмшлийн Ган Китс хамтарсан хувьцаат компани болон дахин зохион байгуулагдсан. Тэрээр төмөр барилгын салбарт цөөхөн хүний нэг бөгөөд Монгол Улсын зөвлөх инженерээр нэр төртэй ажиллаж байна. 100,000 тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлжээ. Ган бүтээцийн мэргэжлийн мэргэшсэн, барилгын зөвлөх инженерүүдтэй Монгол улсын цөөхөн компаниудын нэг юм. Өнөөдөр бид 4 үйлдвэрт 200 гаруй ажилчин, Ган хийцийн төмөр хийцийн үйлдвэрт 70 гаруй ажилчин, Сэндвич "Ган хийцийн сэндвич хавтангийн үйлдвэр" ХХК-ийн 30 гаруй ажилчин, Ган-Эрдэнэ барилгын ХХК-д барилгын суурилуулалтын 40 гаруй ажилчин, "Эко Цаг" ХХК-ийн 100 гаруй ажилчин, "Дорнод Ган Хийц" ХХК-ийн 100 гаруй ажилчид бэхэлгээтэй бетон бүтээцэд ажиллаж байна. Бид 2021 онд төмөр үйлдвэрлэлийн машинууддаа засвар хийсэн. Бүрэн автомат Н төмрийн гагнуурын машин, элс цэвэрлэх тоног төхөөрөмж, цайраар бүрэх буу, CNC зүсэгч машин зэргийг үйлдвэрлэлдээ ашиглаж байна. Манай байгууллага үйл ажиллагаандаа 25тн авто кран, 10 тн-н авто кран 10тн-н маяги кран зэргийг ашигладаг бөгөөд ИТА нарт зориулсан starex тээврийн хэрэгслээр ханган ажилуулж байна.

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ: Бид өөрийн ERP system-ийг хөгжүүлснээр энэ салбарын дижитал хувиргагч тэргүүлэгч компанийн нэг болохоор ажиллаж байна, microsoft 365, чатбот, ЗСХ утасны системд холбогдох. Мөн бид интернэтээр бараагаа борлуулах www.shop.gankhiits.mn нээхээр ажиллаж байна. 2021 он хэдийгээр дэлхий нийтээрээ цар тахлын хүнд хэцүү үе байсан хэдий ч манай хамт олны хувьд хийж бүтээсэн зүйл ихтэй, урдаа тависан зорилго, зорилтондоо хүрэхийн төлөө баг, хамт олноороо хичээсэн маш амжилттай жил болж өнгөрлөө. Төлөвлөсөн ажил 100% биелэхээс гадна төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн болно. Сайны хажуугаар саар зүйлч байлаа. 2021 оны 5 сараас нягтлан бодогчийн суурин компьютерийг шинэчилж Diamond 5.0 санхүүгийн программыг нэвтрүүлсэн.

Өмнөх жилүүдэд нярав нь компьютер байхгүй, бүх бараа материалын орлого зарлагыг нягтлан хөтөлдөг байсныг болиулж няравт бас Diamond 5.0 санхүүгийн программыг нэвтрүүлэн Нягтлан, Нярав 2 уялдаа холбоотой ажилладаг болсон. Ганхийц" гэсэн 30 жилийн түүх, брендинг байна, зах зээлд тодорхой байр суурь эзэлж байна, одоогоор! Зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэж байна, шинэ технологиуд нэвтэрч байна, харилцагч үйлчлүүлэгчдийн зан төлөв тасралтгүй өөрчлөгдөж байна.

Бид шинэ технологи, цахим технологи, инновацийг өөрсдийн үйлдвэрлэлд нэвтрүүлж чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх, зардалыг багасгах улмаар эцсийн хэрэглэгчид илүү хурдан, шуурхай, чанартай, хямд үйлчилгээг санал болгоно.

Бид өөрсдийн "Ганхийц" гэсэн брендийг илүү технологижуулж ребрендинг хийх болно. Бид хэрэгжүүлж буй дижитал шилжилтээ нэг удаа хийгээд орхихгүй, тасралтгүй алхам тугам сайжруулсаар байх болно.

2021 онд Ган Хийц ХК нь нийт борлуулалтаараа 2.853,000,000 төгрөгийн орлогтой, түүхий эд материалын зардалд 1.386,000,000 төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд бусад зардлууд цехийн зардал, удирдлагын зардал, ТУЗ-ийн зардал, НӨАТ-н татвар, ашгийн татвар гээд зардлуудаа хасаад цэвэр ашиг 349,178,304 төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ингээд 2021 оны Санхүүгийн тайланг аудитаар дүгнүүлснээр манай “Ган Хийц” ХК нь 2021 оны 12-р сарын 31-ны өдрөөр тасалбар болгосонтой холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэхэд:

1. 2021 оны хувьд ихэни аж ахуйн нэгжүүдийн хувьд хүндрэлтэй жил өнгөрсөн бол Засгийн газраас гаргасан зарим шийдвэрүүд нь аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг болж тус хэмнэсэн мөнгөө хэрэгцээт зүйлдээ хөрөнгө оруулах боломжийг олгожээ.
2. 2021 онд маш олон өөрчлөлт, шинэчлэлтүүдийг зоригтойгоор хийж ажилчдынхаа тав тухтай ажиллах, ажлын байрны орчныг сайжруулахад чиглэсэн жил байлаа.
3. 2021 онд алба, нэгжүүд болон удирдах багуудын уялдаа холбоог сайжруулах 7 хоног бүрийн нэг өдөр хурал хийж, дээд удирдлагуудад улирлаар төлөвлөгөө гарган, тайланг тавиулж, шийдвэрүүдийг хамтдаа гаргахад анхааран ажиллаа. Мөн жилийн эцэст бүх удирдлагын багын ажилчидтайгаа алдаа оноогоо дүгнэж хийсэн ажлын тайлангаа тавьсан нь бүх хүмүүст урам зориг, шинэ санаа өгсөн гэдэгт итгэлтэй байна.
4. КРІ болон удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэхэд ажлын байр тус бүрийн онцлог, ажил үүргийн хуваарь зэргийг нэг бүрчлэн ойлгосны үндсэн дээр ажилчин тус бүртэй хамтран нэвтрүүлэх урт хугацааны ажил гэдгийг ойлгон ойрын төлөвлөгөөндөө тусган Хүний нөөцийн ажилтантайгаа хамтран судалж байна.
5. Хамгийн гол нь Ган Хийц ХК-ийн хэтийн төлөвлөгөөг боловсруулж урт хугацаандаа хэрэгжүүлж ажиллах маш олон ажлууд судалгааны түвшинд байгааг хэлэх нь зүйтэй.

Ган Хийц ХК-ийн 2021 оны Санхүү болон үйл ажиллагааны тайлангийн талаархи мэдээлэл үүгээр дууслаа. Та бүхэнд хэлэх санал байна уу? Байхгүй бол дүгнэлтээ хэлэх үү?

Д.Ганболд: ТУЗ-ийн даргын 2021 оны Санхүү болон үйл ажиллагааны тайлан дүгнэл маш ойлгомжтой байлаа. Иймд би тайланг хангалттай гэж дүгнэж байна.

Гишүүд: Санал нэг 100% дэмжиж байна.

- ТУЗ-ИЙН 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ, КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн:

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хавсралтаар танилцуулж байна. Компанийн үйл ажиллагааны 2022 оны төсвийг 945,302,720 төгрөгөөр, Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг оролцсон гишүүдийн 10%-ийн саналаар 95,176,720 төгрөгөөр үүн дээр үйлдвэрлэл, худалдаа, төслийн зардлууд 3.0 тэрбум бөгөөд нийт 4.2 тэрбум төсөвлөсөн байна.

Захиргаа аж ахуй болон үйлчилгээний зардал цалингийн санг Гүйцэтгэх захирлын оруулж ирснээр танилцуулж байна. 1.2 тэрбум төгрөгөөр та бүхэнд танилцуулж байна. 2022 оны үйл ажиллагаа болон зардлын төсвийн талаархи төлөвлөгөөг та дэлгэц дээр дэлгэрэнгүй танилцууллаа. Үүнээс асууж тодруулах зүйл байна уу? Хэрэв байхгүй бол саналаа хэлэх үү?

АргайБэст ҮЦК ХХК-Гантуяа: Хэлэлцсэн асуудал дээр нэмэх зүйл байхгүй. 2022 оны төсөв төлөвлөгөөнд нэмэх санал алга байна.

А.Эрдэнэ: Санал хүсэлт байхгүй дэмжиж байна.

- НОГДОЛ АШГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ТАНИЛЦУУЛАХ

“Ган Хийц”ХК-ийн 2022 оны 02 сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас энэ жил Хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг тараах шийдвэр гарч нэгж хувьцааг 100 төгрөгөөр тооцон ноогдол ашиг заасан хугацаанд тараахаар болж шийдвэрлэж мэдэгдэлээ МХБ болон СЗХ-нд хүргүүлсэн. Манай компани нь 2022 оны 3 сарын 21-ны өдрийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс авсан албан ёсны мэдээлэл авснаар нийт 242464 ширхэг хувьцааг ХХК болон иргэдээс бүрдсэн 138 ширхэг хувьцаа эзэмшигч байна.

Энэ асуудал дээр та бүхнээс санал хүсэлт байна уу?

/100% дэмжив. Санал хүсэлт байхгүй/

М.Даваасүрэн Өөр асууж тодруулах зүйл байхгүй бол Тооллогын комисс байгуулж ажилд нь оруулах уу? Тооллогын комиссоор дараахи хүмүүсийг сонгох саналтай байна.

Тооллогын комиссын даргаар: “Ган Хийц” ХК-ийн Хүний нөөцийн менежер Д.Энхчимэг
Гишүүд: Борлуулалтын менежер: Б.Мөнхголомт

Эко Цаг ХХК-ийн нягтлан бодогч Т.Мөнгөнчимэг нарыг дэвшүүлж байна. Та бүхэн дэмжих үү?

/100%-ийн саналаар батлав/

Тооллогын комисс бол хэлэлцсэн асуудлууд дээр нэг санал хуудас хэвлэж санал хураалт авна. Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тарааж өгнө үү./Ирсэн хувьцаа эзэмшигчид саналыг хуудсыг бөглөв/

Тооллогын комиссын дарга Д.Энхчимэг саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол , тогтоолыг уншиж танилцуулав./протокол, тогтоолыг хавсаргав/

Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Ажлын өндөр амжилт хүсч баяр хүргэе.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Ган Хийц ХК-ийн 2021оны үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлан ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.
2. ТУЗ-ийн 2022 оны зардлын төсөв, компанийн үйл ажиллагааны 2022 оны зардлын төсөв батлав.
3. 2021 оны үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн тайлангийн үр дүнгээр ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр тооцон дамжуулан олгохыг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэнд даалгав.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргах буй тогтоолыг уншиж танилцуулснаар хурал өндөрлөв. /тогтоолыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2022 оны 04-р сарын 24-ны өдрийн 12:45 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичгийн дарга

Б.Нина

Танилцсан

Хурлын дарга

М.Даваасүрэн